

“Болор цом 34” наадмын тэргүүн шүлэгчийн ярилцлагыг гүйлгэн уншиж суутал, элэгдэж улирсан оочин цоочин бодлууд гэнэт сэргэх шиг санагдав.

- Оорийг тань яруу найрагч гэж энэ хүмүүс огт мэдэхгүй байна. Мэдэхийг ч хүсэхгүй байгаа бололтой. Эгдүү хүрмээр байгаа биз ! хэмээн сэтгүүлч асуухад найрагч:

– “Ха ха. Хүмүүс мартдаг юм болов уу. Энэ тухай олигтой тайлбар огч чадахгүй байна. Утга зохиолын хүрээнд хүртэл мартаж хүсэлтэй хүн байх шиг байна” гэж хариулжээ.А

Тэгээд ялимгүй бодлогоширолд автав. Ингэхэд хүмүүс чухам хэн, хэнийг мартаж чадахааргүй болтлоо сэтгэл оюундаа тээж яваа, хэнийг мартагнах болсон, хэнийг бүдэг бадаг санаж, хэнийг бүүр огт танихгүй байгааг магадлан нягтлах боломжтой гэж үү? Хэн нэг зохиолчын, яруу найрагчийн, хөгжмийн зохиолч, эсвэл зураачийн бүтээлийг таних эс таних, мартаж эс мартаж асуудал бол манай энэ цагийн бараг ихэнх хүмүүсийн хошууран дагадагчилан “олны танил болж чадсан” эсвэл чадаагүй, “Болор цом”-д дээгүүр байр эзлэсэн, эзлээгүй, цэнхэр дэлгэцээр олонтоо гарч, сонин, сэтгүүл, “совшил медиагаар /ол он нийтийн мэдээллийн цахим сүлжээ

/

ямар давтамжтай үзэгддэгтэй тодийлон холбогдолгүй, оноо, маргааш хийгээд цаг хугацааны хязгаар заагаас ч хамааралгүй зүйл юм шүү хэмээн адран, зорьвдлэх нэгний “бачимдангуй” торх харагдаад далдрах шиг ...

Магад энэ бол хаа нэгтээд, аян замын уртад, аагтай сархадын дэргэд хэдэнтээ сонсож онгороосон халуун яриа, зоримог маргааны хэсэг бусагхан дурсамж сохогдсон хэрэг л дээ.

Уран бүтээлчдийн гол толов халамцуухан байхдаа орнвддэг, хурц, гашуун, эедүү зоолон үгсийн амт хэдэн арван жилийн турш ч мэдрэгдсээр байх нь бий богоод хэзээ нэгтээ гав ганцаараа бодолд эзлэгдэж суухад дотроос цоролзон ондийж, эс богоос учирлан аргадах нь түмэнтээ дотно, дулаахан амуй. Эл учраас улбаалан нэгэн гэгэлзүүр бадаг санаанд унасан нь

“Цаст уулын сууринд Сврэнгийн Бvрнээ нам гvмхэн улирна

Цагаан тvнгэтэй намаржааны холоор давхих морьтон Батболд мон vv...? хэмээн найрагч санаашрах аж. Энэ бол яруу найрагч Гомбосvрээгийн Бямбаагийн “Уянгат нохдоо дурсахуй” гэдэг шvлгийн морvvд юм.

“Хорог зураг Дамдинсvрэн абугай”

Хогжим хэмнэлт Цолмонгийн хуруу...” хэмээн эхлэх эл шvлгийн мор, бадгаас би урьд нь ч хэдэнтээ эш татаж байсныг зарим уншигчид санаж байгаа нь лав. Дээр vгvvлэгдсэн Сврэнгийн Бvрнээ, Уушийн Батболд нараас гадна хэн хvнд vl анзаарагдам шахам аж торж, бvтээлээ туурвисаар “нам гvм, чимээгvйхэн улирсаар” ахуй миний мэдэх одий тодий найрагчид, зохиолчид, уран бvтээлчид газар, газарт бий.

Тэдний тухай дурдъя гэтэл илvv ойр, хажууханд минь болоод ч тэр vv хамгийн эхлээд жинхэнэ Алтайн хох чулуу байсан гэлцдэг Ховдын Баянзулын Баасанжав агсан, Аюушийн Жаргалсайхан, Аварзэдийн Оюунчимэг, Жамбын Томорчулуун, Дашзэвэгийн Орнохдэлгэр, Буяндалайн Цогбадрах, Пvрэвдоржийн Гантомор, Б.Лхагва-очир, Б.Оюунхvvгээс эхлээд Увсын Билэгт хvмvvн гэгдэх Билэгийн Норов абугай, Томорийн Цэдэнсодном, Б.Дагьмэд, Ондорхангайн Д.Энхбаяр, Тэсийн Б.Баттулга, Говь-Алтайн Гочоогийн Чардаг, Цоодол тэргvvтнээс гадна ажиг сураг алсхан Ховсгол нутагтаа суух Пvрэвжалын Майнбаяр гэхчилэн олон олон хvмvvсийн нэр сураг сэтгэлд бууна.

Туулсан амьдралынхаа туршид уулзаж учирч, ижилдэж дассан хэдэн зуун хvний тухай зvрхнийхээ холсоор “хачин овормоц” уран зохиолын дурсгал vлдээмэгц, удалгvй хальж одсон” Б.Баасанжав агсаны “Он цаг холдох тусам одоо юм шиг санагдана, хошууны олон та нар минь бодогдох ч шиг янзтай” хэмээсэн сэтгэлийн хайлан гэнэ, гэнэхэн зvрх рvv орох шиг...

”Суманд амьдрах сайхан” хэмээх хээрийн салхины урь, цас, борооны vнэр анхилуулсан “ходох” шvлгээрээ 2014 оны Болор цомын дэвжээг мялааж асан Сврэнгийн Бvрнээ ахыг маань бас ч гэж олон хvн анддаггvй байхад “Цагаан тvнгэтэй намаржааны холоор давхиж...” vзэгдээд, далдарч одох Уушийн Батболдын тухайд нутаг усныхнаас нь бусад хvмvvс ер гадарлахгvй. Тэр бол яг шvлэгт гарч байгаа шигээ дэндvv зонгоороо,

байгаагаараа нэгэн агаад, тормол авьяасаас нь хэдэнтээ ундрах, цармын гашуун агь шиг шүлгүүдээ тэмдэглэлийн дэвтэр дээр буулгаж хадгалахаас хэтрэхгүй, олны хүртээл болгох, сурталчилан таниулах энэ тэрийг барагтай бол тоодоггүй, бор баарагдуу нохор.

“Түүж оргосон шүлэг гал минь

Түгээж цацдаг зүрхний анир минь

Замд таарах эртний анд минь

Таньд оргох бэлэг ном минь...

....нарнаас авдаг амьсгал минь

Намраас зээлддэг гуниг минь

Хавраас хүртдэг баяр минь

Хамтдаа явдаг онгод минь..” гэх мэтээр түүний шүлгүүд нэг сонсвол бодлоос ер гарахааргүй.

“Хорвоод хүн үүсэхдээ хоосон байжээ

Хоёр биенээсээ илүүчлэх хогшилгүй байжээ

Тэнгэрээс нар зээлдэж илчээ хийсэн юм байна

Толгодоос цэцэг зээлдэж үнэрээ олсон юм байна

Моронгоос дусал зээлдэж цусаа сэлбэсэн юм байна

Моддоос навчис зээлдэж, ол залгасан юм байна...” хэмээн учирлана. Зах зээлийн шуурга, амьдралын урсгалд туугдсаар, энэ найрагч Цаст, Мөнххайрхан уул, буйдхан ходоогоо орхиод, аймгийн товд суурьшисан агаад ажилгүйдэл, амьдралын алагчлал, дутуу гацуу, хямрал донсолгооны эргүүлгэнд сэгсчигдэж, чимээгүйхэн шаналж явах шиг санагдах ч амьсгалах нь нарны энтэй, гуниглах нь намрын араншинтай түүний юунд ч юм нэг л даамай итгэл үргэлж цухалзана.

Ховд, Увс, Баян-Олгий гээд баруун аймаг дахь идэр, залуу насны найрагч, зохиолчид, уран зохиолд шимтэгчдэд загалмайлсан эцэг гэгдэх ардын цэргийн бэлтгэл дэд хурандаа Аюушийн Жаргалсайхан зохиолчтой уулзаж, учрааггүй, яриа хоороо орнүүлээгүй, “Явуугийн модны дэргэд ч юм уу, явуулын тэрэгний бүхээгт хундага тулгаагүй нь энэ нутгийнхан болоод ирж, очиж байсан утга зохиолын хүрээнийхэн дотор тун ч ховор болов уу.

Хэн гуайтай ч, ямар ч сэдвээр яриа орнүүлэх, цэц булаалдан, ном тавилцах олхон чадвартай, уншиж судалсан, үзэж сонссон нь чухам хэдэн тэрэг ном болмоор амьдралын их туршлагатай эл эрхэмтэй “буу халахад” үнэн урамтай. Жагаа ах маань гол толов хүүрнэл зохиолын богино хэлбэрээр бичиж, үгүүллэг, туужийн бас яруу найргийн хэд, хэдэн ном хэвлүүлсэн. Яруу найрагч Хоодоогийн Эрдэнэбаатарын түүнд зориулсан шүлэглэснээр “Уулын хэцийн манан шиг учир битүүлэг” энэ зохиолч нэр алдартай зохиолчдын ном зохиол, үг ярианаас эш татан, сонирхолтой хууч дэлгэж, цэнхэр дэлгэцээр тэднийг гарвал хүүхэд шиг баярлаж, шимтэн дурлах агаад эгэл, энгийн ийм зан торхоороо амьдралын нэгээхэн орон зайг үүрч явах шиг санагдах. Аварзэдийн Оюунчимэг эгчийн бас л ямар ч сэдвээр аль А ч талаас нь даацтай, далайцтай авч үзсэн, сонирхолтой ярианд нь шимтэн шимтэмээр. Ажлынхаа зэрэгцээгээр орчуулж буулгасан, бичиж ноороглосон оч точноон зүйлүүдээ дэлгэн үзүүлж, амтат яриандаа автахдаа нэг ёсны “кайф” авч, түүнээсээ таашаал эдлэж байх нь мэдрэгдэнэ.

Энд би санамсаргүй одоогдсон санаа бодлынхоо вэвүрт хотлогдон, гагцхvv оорийн сайн таньдаг, уулзаж учирч, ярьж хоорч явдаг цоон хэдэн хvмvвсийн талаар санаанд илхэн буй ганц нэг зvйлсийг цухасхан дурьдсан тодий юм. Энэ мэтээр тэр бvр олны хараанд ортож, анзаарагддагвй ч уран бvтээлд vнэн сэтгэлээ огч, заавал бvтээж туурвидагвй байлаа гэхэд тvвнд шимтэн дурлаж, утга, уран зохиол, урлаг соёлын ертонцоор аялан хэсvвчлэгч сэтгэл нэгт нохдийг нэг бvрчлэн дурьдана гэвэл энэ багашаархан бичвэр маань хэд дахин сунах учраас ингэсхийгээд товчлоё гэж бодно. Бас ямар ч атугай зохих тvвшинд олноо танигдсан, хэр хэмжээндээ нэр алдарт хvрсэн найрагчид, уран бvтээлчид ч миний vгvвлэн буй нутаг орны хvрээнд ганц хоёроор зогсохгvй хийгээд тэдний талаар энэ удаад дурьдахыг азнасан билээ. Â Â Â Â Â Â

Галзад Томорийн Цэдэнсодном гэх танхай авъяст нэгэн хаа сайгvй хэрэн хэсvвчилж, эрх дураараа ч гэх юм уу, этгээд ойлгомжгvй ч гэх юм уу, яг л цыган шиг амьдрах агаад, оноодор энд, маргааш тэнд, нэгэнтээ ор сураггvй алга болсноо, хаа нэг газарт чухам хаанаасыг бvв мэд гэнэт гараад ирчихсэн байх.

“Эхний болоод эцсийн хох замаар

Эцэнги морьтой богтор шогшином

Элчилгvй холд тэнэмэл салхийг хотолж

Эгц хяр дээгvвүр богон давнам

Овсний хурим, могойн чуулганд

Овгон модны зарыг хvргэнэм

Улиг дарс тархийг идэж

Ужиг овчнийг сэдлэн байнам...” энэ юуг vгvүлнэм бэ? Â Магадгvй оорийнхоо хэрмэл амьдралын замыг заасан “нууц тэмдэг” мэт санагдах нь нэн сонин.

“Хуур чарлуулж, довон дээр богтор суунам

Хуурай дэрс шатааж, долоон veе дууднам

Сансрын хохомдог гэрэлд хvүгээ vнсэж

Сарны холчvү сормуусанд шvүлгээ зvүнэм...” гэснийг vзвээс тэртээх хол сансар хийгээд энэтээх эгэлийн хорвоо дахь орон зайд нэгэн зэрэг амьдраад байх шиг.... ер бусын гайхширам. Заяа бандида Намхайжамцын овог эцэг “Хунку заяач”-ын тухай, мон домогт Ану хатны торсон эцэг Ойрдын их баатар “Галдмаа буюу Галдамба”-ын тухай (*Ану хатанг Ойрдын Очирт цэцэн ханы охин хэмээн өвөг эцгээр нь овоглох явдал тvүгээмэл тархсан хэдий ч тvүхэн vнэний хувьд энэ мэдээ ташаа бөгөөд Ану хатан нь Очирт Сэцэний хvү*

Галдмаа

Галдамба

)

баатрын охин болох нь тодорхой баримтаар нотлогддог

)

дуулалт жvүжvүд болон тайз дэлгэцийн, тvүхэн голдуу анхдагч, ховор бvтээлvүд нэлээдийг туурвисан ч тvүнийгээ ер хайхрахгvй шахам, оноо л У.Батболдтой адилхан олонд таниулах гэж ямар нэг алхам хийх нь vгvй.

Ховсголийн Бvрэнтогтохын уугуул Пvрэвжалын Майнбаяр найрагчтай нутаг алс ч гэлээ дэргэд юм шиг хэлхээ холбоотой байдаг маань цагийн vр, хувь заяаны ероол ч байж магад. Утга зохиолын хvрээнийхэнд ондор vнэлэгдсэн яруу найргийн олон ном бvтээл туурвиж, “Алтан од”-ийн эзэн болж, МЗЭ-ийн шагнал гардсан тvүнийг зохиолчид, утга зохиол судлаач, сонирхогчид андахгvй хэдий ч жирийн олон бол тэр бvр мэдэхгvй. Нутгийнхаа хэн нэгэнд тvүний тухай vгvүлтэл “оо “Болор цом” аваагvй найрагчийг бид яаж таних вэ дээ” гэсэнсэн. Нээрээ л манай олон нийт “Болор цом” атгаагvй ч юм уу, тэр наадамд дээгvүр байранд давхиагvй бол нэрд гарсан яруу найрагч бус гэж vзэж буй энэ цагт Майнбаяр найрагч, цом гардаж, нэрээ монхлохгvй, хойргошин суугаа нь нэг л базаахгvй зvйл дээ гэх шvү юм бодож, тэр эрхэмийг зовтгохоос аргагvй болсонсон. Â Â Â

Â Â Â

Â Ийнхvв “цом”-ын тухай яриа цухалзах тодvйд миний vгvвлэн буй ходооний голдуу “болхи, толхи” нохдийн маань дунд хааяа нэгхэн орноод авдаг “чих халууцам” яриа хоороо сэлтvвд зурасхийгээд онгорно. Ховдын найрагч Баасанхvвгийн Баяраа нэгэнтээ “Болор цом”-ын эзэн болсон найрагчийн тэргvвн шvлэг нийтлэгдсэн “Утга зохиол урлаг” сонинь дугаарыг барьчихсан халамцуухан ороод ирэв. “Энэ шvлгийг чи хар даа. Эхний хэсэг дэх хоёр морийг сvвлчийнхээ хэсэгт дахиад хуулаад тавьчихсан байх. Бичих vг нь олдохгvй болохоор ингэдэг бололтой. Тэгээд хоорхий шvлэг ч гэж шvлэг л юм. Овог дээдсээ магтаж сайрхаад байгаам уу гэтэл тvрэмгий, эзэрхvвгээр нь дуудаж шоглож тохуурхаад ч байгаа юм шиг холион бантан л байна шvв дээ” гэж байна. Хэлснийг нь лавлаад уншиж vзвэл нээрээ л тийм анзаарагагvй алдаа гэхээр зvйлvвд байж л байсан. Энэ мэтчилэн хурц гярхай, билэг танхай хэрнээ эгэл боргилхон нохдийн дундаас нэгэн аравны чолоонд нэрийг олоогvй хэдий ч хэдэн зуунаар тасрахгvй дориун сайн зохиол бvтээл туурвин буйг хэн, хэрхэн шvвн дэнслэж чадахсан билээ...

Гэсэн ч дээр цухалзуулсанчилан оноо цагийн олон нийтийн ойлголт внэлэмжээр бол болор цом авагvй, ямар нэг уралдаан тэмцээнд тvрvвлж, байр эзлээгvй, нэр нолоо ихтэй хэн нэгэн хvний внэлэмж магтаалд хавчуулагдаагvй, цэнхэр дэлгэцээр олон удаа гарч, танигдаагvй бол шальтай зохиолч, найрагч, уран бvтээлч биш болж таарна.

Орон нутгийн хэсэг зохиолчид уран бvтээлчид хамтраад, аймгийнхаа тор захиргааны зvгээс явуулж буй соёлын бодлогын талаар санал бодлоо илэрхийлэхээр, бас тодорхой санал дэвшvвлэхээр ажил хариуцсан даргатай уулзаж л дээ. Тэгтэл “та нар муусайнууд нэрд гарч, олны танил болоогvй байж юугаа яриад байгаа юм. Бид олонд нэр сvрээ дуурсгасан том зохиолчид, уран бvтээлчдийг нийслэл хотоос урьж, хамтарч ажиллана. Та нар мэтсийн хувьд бол арай болоогvй байна” гэх шvв юм ярихад нь манай ноход ч мочоогоо огохгvй мэтгэлцэх аядаад, оноох даргын бvвр дургvйг нь ходолгож орхисон явдал бий.

Олны энэ мэт аяс хандлагууд юуг илэрхийлж байна гэхээр зохиолчид уран бvтээлчид, судлаач эрдэмтдийн бvтээл туурвилыг уншиж судлаж, оорийн оюунаар мэдрэхээсээ илvвтэй, дээр vгvвлсэн хийсвэр vзvвлэлтээр урьдчилан внэлгээ тогтоож, амарчилан дvгнэх дуртай, хамхуул шиг салхины аясыг дагаж хийсэх дуртай, нэг тийм ямар ч гэмээр юм бэ дээ сэтгэлгээг энэ цаг ve маань хvмvвст “толовшvвлж” байх шиг. Â

Дээрээс нь уран бүтээлчдийн санал бодлыг сонсох, тэдний омоо тулгарч буй аливаа асуудлыг авч үзэх, хэлэлцэх, шийдэл гаргахын толоо хичээх энэ тэр бол манай оноодрийн торийн бодлогод бараг л “хориотой” шахам зүйл гэхэд хилсдэхгүй. Иймэрхүү зүйлийг холбогдох албаны хүмүүстэй ярих юм бол бодлого толоолтонд тийм юм байхгүй юм чинь бид яах вэ дээ хэмээн үнэнийг очих учир, ойлгоод л чимээгүй болох нь зов гэхүү дээ. Ийм нохцолд амьдрал, амь зуулгынхаа хажуугаар уран бүтээлийн мор хоож, түүний толоо явна гэдэг бол ёстой ногоо “ногоон тэмээний хажуу” гэмээр авч, уран бүтээлчид бас ч гэж гандан буурахгүй хийдгээ хийсээр байх нь атаархал торүүлэх шиг. Â Â

Магадгүй энэ байдал бидний оорсдийн маань хувьд нийгмийн тулгарсан асуудлын талаар бодож санаж, зовниж, шаналж, байгаагаа илэрхийлж тэмцдэггүй, аясыг харамтгай, зарим талаараа аялдан дагалдамтгай, эсвэл хэтэрхий ихэрхэн бодож, энэ нийгэм, улс торийн явдал бидэнд падгүй, бид үүнээс хувь илүү дээд сууринд очсон хүмүүс, ийм аар, саартай зууралдахгүй гэх янзын санаа агуулдагаас болж байна гэсэн утгатайгаар энэ цагийн нэрт бичгийн хүн хэмээн миний хүндэтгэж явдаг зохиолч, нийтлэлч, сэтгүүлч Баасангийн Наминчимэдийн бичсэн нь эрхгүй санаанд бууна.

Дашрамд нь утга, уран зохиол, урлаг соёлын мон чанар, үндэс язгуур хийгээд ноолоо сүүдрийн талаарÂ эрэгцүүлэхийг хичээвэл тэдгээр нь хүний амьдралын хэдэн үеэр зогсохгүй хэдэн зуу, мянган жилээр зүрх сэтгэлд оршиж, амьдрах хосгүй чадварыг их, бага хэмжээгээр агуулсан байх агаад үүний үнэлэмж нь аливаа зүйлийн амт, шимтийг шингээн, ойлгож авч байж, сая дүгнэн бодох хэмжээний зан чанарыг оортэй бий болгосон соёлт ард түмэн хийгээд бүхнийг тунгаах сүүлчийн найдвар гэгдэх цаг хугацаанд л байх болов уу гэсэн мөхсө бодолд “ороогдоно”.

Яагаад ч юм би үл анзаарагдам атлаа ер бишийн соньхон, тийн нам гүмхэн хорвоод дуртай билээ.Â Â

Хэн нэг уран бүтээлч аг чигхэн аж торсоор, ямар нэг соньхон бүтээлээ оороосоо бусдад үзүүлэлгүй шахам хадгалсаар хожмын одруудад үлдээгээд одох, хэнэггүйхэн зарим нохдийн маань моноо танигдаагүй шахам зохиол номтой тааралдсан нэгэн “шалихгүй амьтан биз ээ” гэх шүү юм бодож тоомжиргүйхэн ширвэх, жил жилийн “Болор цом”, “Алтан од”-ийн тухай ч юм уу, “бэстселлер” болж /цууд гарсан/ гэх, сургаар тодорсон сүрхий эрэлттэй бүтээл номын тухай шуугин дарвих, шивэр авир гэх сэлтүүд энэ цаг дор эрээлжилнэ.

